



2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛ

САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

01. Бизнесийн үйл ажиллагаа

Онцлох үйл явдал



“Сэндли ББСБ” ХК-ийн 58 дахь салбарыг Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудалд шинээр нээсэн. Одоогийн байдлаар бэлэн болон бэлэн бус валют арилжаа хийгдэж байна.



“Сэндли ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 3 дугаар сарын 31-ний танхим цахим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулсан.



2024 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 7.61 төгрөг нийт 1,701,367,700 төгрөг /татвар суутгаагүй дүнгээр/ тараахаар шийдсэн ба 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулсан.

Онцлох үйл явдал



“Сэндли ББСБ” ХК-ийн 2024 онд гаргасан "SNDB" нээлттэй бондын ээлжит хүүгийн төлөлтийг 2025 оны 02 сарын 06-ны өдөр Үнэт цаас эзэмшигчдийн дансанд байршуулсан.



Panda Remit компанитай хамтын ажиллагааны хүрээнд Австрали, Канад, Сингапур, Хонгконг улсаас Монгол улсруу шилжүүлэг хийдэг боллоо.



2025 оны 4, 6-р саруудад нийт ажилтнууд болон сумдын захирал нарт зориулсан сургалтыг зохион байгуулсан бөгөөд 5 төрөлт спортын тэмцээнийг хоёр дахь удаагаа амжилттайгаар зохион байгуулсан.

Онцлох үйл явдал



ISO 27001:2022 стандартад амжилттай шилжин, АНУ-ын итгэмжлэлтэй MonCertf LLC - First Mongolian International Certification Organization ын гэрчилгээг авсан.



"Сэндли ББСБ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж, компанийн санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх, цаашдын өсөлт хөгжилд суурь тавих зорилгоор өөрийн хөрөнгийг 12.4 тэрбум төгрөгөөр хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэхээр шийдвэрлэлээ.

Зээлийн үйл ажиллагаа

Зээлийн хураангуй тоон үзүүлэлт:

Зээлийн багцын
үлдэгдэл

95.6
тэрбум ₮

Нийт олгосон
зээлийн дүн

140.1
тэрбум ₮

Дундаж зээлийн
үлдэгдэл

3.4
сая ₮

Зээлийн багцын
өсөлтийн хувь өмнөх
оны эцсээс

21.8%

Зээлийн үлдэгдэлтэй
харилцагчийн тоо

27,841

Зээл авахаар
бүртгүүлсэн шинэ
харилцагчийн тоо

22,859+

Лизингийн зээлээр
хамтран ажиллах
дэлгүүрийн тоо

190+


Зээлийн багцад
ээлэх чанаргүй
зээлийн хувь

5.8%

68.5 тэрбум ₮

72%

Уламжлалт



27.1 тэрбум ₮

28%

Финтек

Бидний зүгээс хэрэглээний зээл болон цахим зээлд FICO оноог бүрэн нэвтрүүлсэн. Ингэснээр эрсдэлийн бодлоготой уялдуулан гар ажиллагааг бууруулан, зээлийн судалгааны хурд, чанарыг үе шаттай сайжруулан, технологид суурилсан дэвшилтэт шийдлүүдийг нэвтрүүлэн хөгжүүлж ажиллаж байна.

Зээлийн үлдэгдэл (статус, хүйсээр):

45.18 тэрбум ₮

47.2%

Улаанбаатар хот

50.42 тэрбум ₮

52.8%

Орон нутаг



Эмэгтэй

52%




Эрэгтэй

48%




Зээлийн үйл ажиллагаа


Зээлийн багц (сая төгрөг), зээлийн тоо:




Олгосон зээл (сая төгрөг):



Чанаргүй зээлийн эзлэх хувь:



Мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа



- 2020-2021 оны хооронд АНУ, Австрали, Япон улс
- 2022 онд Европын холбооны 27 улс, БНХАУ-ын Wechat
- 2023 онд БНХАУ-ын Alipay, 80 улсад Visa&Master карт
- 2024 онд PandaRemit хамтран Монгол улсаас АНУ, Австрали, Канад болон Хятад улсруу
- 2025 онд Сингапур, Австрали, Хонг Конг, Канад улсаас Монгол чиглэлд тус тус гүйлгээ хийх боломжтой болсон.



02. Санхүүгийн үзүүлэлт

Санхүүгийн тайлан

(Аудитлагдаагүй)

/сая төгрөг/	2024 II	2024 III	2024 IV	2025 I	2025 II
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,973	6,126	16,616	4,650	13,642
Зээлийн багц (Нийт)	52,674	68,880	78,453	99,840	95,631
Зээлийн эрсдэлийн сан	-1,981	-2,314	-2,758	-3,377	-3,976
Бусад хөрөнгө	11,251	5,815	7,133	8,260	12,864
Үндсэн ба биет бус хөрөнгө	1,275	747	759	787	1,125
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	66,192	79,254	100,202	110,161	119,286
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	19,161	21,422	25,758	27,224	26,805
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	6,500	12,000	21,103	26,570	27,704
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	8,500	10,000	15,000	15,000	15,000
Бусад өр төлбөр	2,094	4,208	4,224	4,613	12,249
Нийт өр төлбөр	36,256	47,630	66,085	73,408	81,758
Өөрийн хөрөнгө	29,936	31,623	34,117	36,753	37,528
Энгийн хувьцаа	11,179	11,179	11,179	11,179	11,179
Нэмж төлөгдсөн капитал	6,285	6,285	6,285	6,285	6,285
Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг	8,124	8,124	8,139	16,563	14,787
Тухайн үеийн хуримтлагдсан ашиг	4,335	6,022	8,502	2,621	5,102
Бусад өөрийн хөрөнгө	14	14	13	106	176
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66,192	79,254	100,202	110,161	119,286


Зээлийн багц
өмнөх оны
мөн үеэс

81.5% ↑


Нийт актив
өмнөх оны
мөн үеэс

80.2% ↑

Нийт зээл (сая төгрөг)



Нийт хөрөнгө (сая төгрөг)



Хөрөнгө активийн
өгөөж

5.5%

Өөрийн хөрөнгийн
өгөөж

15.1%

Орлогын тайлан
(Аудитлагдаагүй)

/сая төгрөг/	2024 II	2024 III	2024 IV	2025 I	2025 II
Хүүгийн орлого	9,793.79	15,383.55	22,538.52	7,645.78	16,722.29
Хүүгийн зардал	3,311.10	5,101.20	7,271.94	2,918.15	6,137.58
Цэвэр хүүгийн орлого	6,483	10,282	15,267	4,728	10,585
Хүүгийн бус орлого	2,554.03	3,854.76	5,183.44	1,386.15	2,984.71
Хүүгийн бус зардал	4,142.84	6,643.18	9,205.08	2,582.76	6,682.17
Цэвэр хүүгийн бус орлого	(1,589)	(2,788)	(4,022)	(1,197)	(3,697)
Нийт үйл ажиллагааны орлого	4,894	7,494	11,245	3,531	6,887
Болзошгүй эрсдлийн зардал	331.17	664.29	1,108.31	618.80	1,218.42
Татварын өмнөх ашиг	4,563	6,830	10,137	2,912	5,669
Орлогын албан татвар	227.85	807.41	1,634.16	291.22	566.88
Тайлант үеийн цэвэр ашиг	4,335	6,022	8,502	2,621	5,102

Цэвэр ашиг
өмнөх оны
мөн үеэс

17%




Хүүгийн болон
хүүгийн бус орлого
өмнөх оны мөн үеэс


60%




Цэвэр ашиг өссөн дүнгээр
(сая төгрөг)



Орлого өссөн дүнгээр
(сая төгрөг)



Хувьцааны ханш



Үнэт цаасны код: **7914**

Зах зээлийн үнэлгээ: **34,923,869,700**

Хаалтын ханш (2025.06.30): **156.21**

Хувьцаа эзэмшигчдийн тоо (2025.03.14): **8213**

Гаргасан хувьцааны тоо ширхэг: **223,570,000**

EPS **6.85**

P/B **3.12**

03. Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлага

Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг Юу Пи Ар консалтинг ХХК-аар хийлгэсэн. Тус Эрсдэлийн үнэлгээнд өндөр-8, дундаас дээш-0, дунд-27, бага -145 үзүүлэлт үнэлэгдсэн. 2025 оны 6-р сард дахин үнэлгээ хийлгэж эрсдэлийн түвшинг бууруулан ажилласан.

Эрсдэлийн удирдлагын бодлого зохицуулалтын хүрээнд зохицуулагч байгууллагаас гаргасан тогтоол, журам, эрх зүйн актанд нийцүүлэн 2025 онд “Мэдээллийн аюулгүй байдлын бодлого” шинэчлэн баталж ажилласан. ББСБ-ын зээл, зах зээл, үйл ажиллагааны эрсдэлийг улирал бүр тодорхойлон ТУЗ-д танилцуулан холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна.


Дотоод аудитын тогтолцоо

- Дотоод аудит нь ББСБ-ын үнэ цэнийг нэмэгдүүлэх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бий болгон салбарын хууль, журам, зааварт нийцэж байгаа эсэхэд хяналт тавиж, эрсдэлээс урьдчилан сэргийлж зөвлөмж гарган ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилд 9 салбарт газар дээрх иж бүрэн шалгалт хэрэгжүүлсэн. Зайны хяналт шалгалтыг гүйцэтгэж, сар бүр зайны хяналтын тайлан боловсруулан ажиллаж байна.
- “Хамгаалалтын 3 шугам” загварын дагуу дотоод хяналтын тогтолцоогоо бүрдүүлэн шат дараалласан хяналтын системийг тогтоосон. Газар дээрх хяналт шалгалтыг зайны хяналтаар илэрсэн зөрчилд тулгуурлан, төлөвлөгөөт болон гэнэтийн байдлаар хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Зээлийн мэдээллийн санд (ЗМС) бүртгэгдсэн лавлагааны дагуу олон давхардсан зээлтэй, 2025 онд зээлийн чанарын ангилал буурах эрсдэлтэй зээлдэгчдийн эрсдэлийг үнэлж, холбогдох шинжилгээг хийсэн бөгөөд уг эрсдлийг бууруулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна.

Зохистой харьцааны үзүүлэлт

Харьцаа үзүүлэлт	Байвал зохих	2023	2024	2025-II
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	40.2%	33.2%	29.4%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	40.2%	33.2%	29.5%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	8.8%	70.8%	93.9%
Зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө төлбөрийн баталгааны зохистой харьцаа	30%-иас хэтрэхгүй	9.5%	7.8%	9.0%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	/+/-40%/	-26.2%	-34.1%	-38.6%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	79%	75.5%	71.4%
Өрийн бичгийн зохистой харьцаа	30%-иас хэтрэхгүй	33.8%	43.9%	40.0%
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-иас хэтрэхгүй	0.3%	0.2%	0.2%

Үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээний матриц 2025-II



Анхаарвал зохих үйл ажиллагааны эрсдэл

Мэдээлэл технологийн эрсдэл

- Мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой технологийн эрсдэл.

Гадаад хүчин зүйлтэй холбоотой хууль эрх зүйн эрсдэл

- Зохицуулагч байгууллагаас гаргасан шийдвэрийн хүрээнд, бизнес төлөвлөгөө, хүлээгдэж буй ашигт ажиллагаа буурах
- Эх үүсвэртэй холбоотой эрсдэл бий болох. Итгэлцэл, Бонд, Арилжааны банкнаас авсан зээл. Бонд буюу өрийн бичгийн зохистой харьцаа алдагдах эрсдэл.

Дотоод үйл ажиллагаатай холбоотой эрсдэл

- Нэг зээлийг нөгөөгөөр хаах байдлаар давтамжтай зээл авдаг зээлдэгч нарын хувьд өр, орлогын харьцаанаас хамаарч цаашид шинэ зээл авах боломж багасах эрсдэлтэй. Үүний улмаас зээлийн хугацаа хэтрэх, төлбөрийн эрсдэл нэмэгдэх магадлалтай.

04. Компанийн засаглал

Хувьцаа эзэмшигчдийн
бүтэц

№	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Эзлэх хувь	№	Хувьцаа эзэмшигчид	Эзлэх хувь
1	Монголын финтек групп ХК	174,240,222	77.90%	1	Монголиан мючуал финанс групп ХХК	85.30%
				2	Жижиг хувьцаа эзэмшигчид	14.70%
2	Сэндли эмплойе	20,000,000	8.90%	3	Монголын финтек групп ХК	61%
				4	Ажилтнууд	39%
3	Олон нийт	18,779,880	8.40%			
4	Ажилтнууд	10,549,898	4.80%			
	Дүн	223,570,000.00	100.00%			

Ногдол ашгийн бодлогын
хэрэгжилт

“Сэндли ББСБ” ХК нь 2022 оны есдүгээр сард компанийхаа 29.97 хувийг олон нийтэд санал болгосноор нээлттэй хувьцаат компани болсон ба бизнес төлөвлөгөөний дагуу 2025 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 05 тоот тогтоолоор 2024 оны цэвэр ашгаас 20.01 хувь буюу нэгж хувьцаанд 7.61 төгрөг нийт 1,701,367,700 төгрөгийн ногдол ашгийг 2025 оны 4 дүгээр сард олгож ажилласан.

Ногдол ашгийн бодлогын хэрэгжилт	Нэгж хувьцаанд ногдох ашиг	Ногдол ашиг тараах цэвэр ашгийн хувь	Ногдол ашиг дүн	Ногдол ашиг олгох өдөр
2023 он	2.75	20.06%	614,817,500	2023.07.03
2024 он	5.60	20.68%	1,251,991,232	2024.04.03
2025 он	7.61	20.01%	1,701,367,700	2025.04.10

Хувьцаа эзэмшигчдийн хурал

“Сэндли ББСБ” ХК нь Монгол улсын хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хороо бусад зохицуулагч байгууллагаас баталсан холбогдох дүрэм, журам, засаглалын кодексыг үйл ажиллагаандаа бүрэн мөрдөн ажилладаг. Өнгөрсөн онд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн 98.6 хувийн үнэлгээгээ авч 1-р байранд орсон. Уг ажлын хүрээнд нээлттэй хувьцаат компанид тавигдах шаардлага, шалгуурыг ханган биелүүлж, үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

2025 оны эхний хагас жилд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг тухай бүр олон нийтэд www.mse.mn вэб хуудсаар дамжуулан ажилласан. 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн ердийн 6, хараат бус 2 гишүүнийг улируулан, хараат бус 1 гишүүнийг шинээр тус тус сонгосон. Мөн ТУЗ-ийн 2025 оны төсөв баталсан.

2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх тухай болон компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах шийдвэр гарсан. Ингэснээр ББСБ-д дараах давуу тал бий болно:

- Өөрийн хөрөнгийн бүтцийг сайжруулна
- Санхүүгийн тайланд энэ төрлийн өглөг нь 2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө гэж бүртгэгддэг тул зохистой харьцаа, зохицуулалтын шаардлага хангахад давуу талтай.
- Хувьцаа гаргахгүйгээр хөрөнгө татах боломж
- Хувьцаа гаргах нь хувь эзэмшигчдийн хяналт сулруулах эрсдэлтэй. Харин хоёрдогч өглөг нь эзэмшлийн бүтэц өөрчлөхгүйгээр хөрөнгө оруулалт татах боломжтой.
- Өрсөлдөх чадвар нэмэгдэнэ
- Эргэлтийн хөрөнгө, шинэ төсөл, технологи зэрэгт нэмэлт санхүүжилт босгож, ашгийн түвшинг нэмэгдүүлнэ.
- Бонд, итгэлцлийн үйлчилгээгээр хөрөнгө татан төвлөрүүлэх хэмжээ нэмэгдэнэ.

Компанийн засаглал

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

“Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2025 оны эхний хагас жилд 2 удаа хуралдаж 8 тогтоол гарган ажилласан. Уг хурлуудын тогтоолыг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд тухай бүр олон нийтэд мэдээллэн ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

“Сэндли ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн дараах байдалтай ажиллаж байна.

№	Хороодын нэр	Дарга	Гишүүд
1	Аудит, эрсдэлийн удирдлагын хороо	Б.Цэлмэг /Хараат бус гишүүн/	Ч.Заяа /Хараат бус гишүүн/
			Н.Билгүүн /Ердийн гишүүн/
2	Цалин урамшууллын хороо	Ч.Заяа /Хараат бус гишүүн/	Ц.Саруултуяа /Хараат бус гишүүн/
			Б.Эрдэнэ /Ердийн гишүүн/
3	Нэр дэвшүүлэх хороо	Ц.Саруултуяа /Хараат бус гишүүн/	Б.Цэлмэг /Хараат бус гишүүн/
			Л.Нарантуяа /Ердийн гишүүн/



Б.Наранбат

ТУЗ-ийн дарга
Сангийн Яам, Төрийн Банк,
Монголиан Финтек Групп ХК



М.Цолмон

ТУЗ-ийн гишүүн
Сангийн Яам, Тариалан Эрхлэлтийг
Дэмжих Сан,
Монгол Алт ХХК



Б.Эрдэнэ

ТУЗ-ийн гишүүн
Сангийн Яам, Төрийн Банк,
Техбокс ХХК



Н.Билгүүн

ТУЗ-ийн гишүүн
Сангийн Яам, Selius Nomads ХХК,
Инвестлаб Ви Си ХХК



Н.Цэвэгмид

ТУЗ-ийн гишүүн
Райнос Инвестмент ҮЦК ХХК,
Мирэ Эссет Секьюритис ҮЦК ХХК



Л.Нарантуяа

ТУЗ-ийн гишүүн
Зоос Банк, Төрийн Банк,
Монголиан Финтек Групп ХК



Ч.Заяа

**ТУЗ-ийн хараат бус гишүүн,
Цалин урамшууллын
хорооны дарга**
PWC Mongolia Аудитор,
Рэссол Констракшн ХХК



Б.Цэлмэг

**ТУЗ-ийн хараат бус гишүүн,
Аудит, Эрсдлийн удирдлагын
хорооны дарга**
JP Morgan, SMBC Aviation Capital,
Хас Банк, Ашид Капитал ХХК



Ц.Саруултуяа

**ТУЗ-ийн хараат бус гишүүн,
Нэр дэвшүүлэх,
Голомт Банк, Тайвань ШУТИС,
МУИС Бизнесийн сургууль**



Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р
хороо, 40,50 мянгат Бакула ренбүчи гудамж 8/4
Утас: +976 77997700
Имэйл: info@sendly.mn
Вэбсайт: www.sendly.mn